

2025.07

VIP 76+

126
ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ
ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ



ХӨГЖЛИЙН
ХУРДАСГУУР НЬ
ЦАГ ҮЕДЭЭ
НИЙЦСЭН,
УЯЛДААТАЙ
БОДЛОГО,
ХЯНАЛТЫН
ОНОВЧТОЙ
МЕХАНИЗМ ЮМ

Нацагдорж

БАТСҮМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Монгол Улсын Их Хурал



Нацагдорж БАТСУМБЭРЭЛ


- Монгол Улсын Их Хурлын гишүүн
- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн
- Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дарга



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ
ТАНИЛЦАНА УУ

 batsumberel@parliament.mn

 Нацагдоржийн Батсүмбэрэл

 51266103

САНААЧИЛСАН ХУУЛЬ

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
- Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай
- Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Цусны донорын тухай
- Эрхтэн эд, эс шилжүүлэн суулгах тухай
- Харьяатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН

- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хэсэг
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг
- Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг
- Цөмийн энергийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг
- “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэх ажлын хэсэг
- “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг
- Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг
- Бусад

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Унгар Парламентын бүлгийн дарга
- Монгол-Австри Парламентын бүлгийн дарга
- Монгол-Туркменистан Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Израил Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Арабын Нэгдсэн Эмират Парламентын бүлгийн гишүүн



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2025

ХАМГИЙН ОЛОН ХУУЛЬ САНААЧИЛСАН УИХ-ЫН ГИШҮҮН



Эх сурвалж: Lemon press, 2025.06.09

2024 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ



Эх сурвалж: uih.mn



126 ГИШҮҮНТЭЙ АНХНЫ ПАРЛАМЕНТЫН 1 ЖИЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

УИХ-ын гишүүн

ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР НЬ ЦАГ ҮЕДЭЭ НИЙЦСЭН, УЯЛДААТАЙ БОДЛОГО ХЯНАЛТЫН ОНОВЧТОЙ МЕХАНИЗМ ЮМ

10

БҮСЧИЛСЭН БОДЛОГООР МОНГОЛ
УЛСЫН ЦУСНЫ НӨӨЦИЙГ
БҮРДҮҮЛНЭ

12

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН
СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭЛХИЙН
ЖИШИГТ НИЙЦҮҮЛНЭ

14

АМЬ НАСАНД ХАЛТАЙ СКУУТЕР,
СУРРОНЫ ХЭРЭГЛЭЭГ ХУУЛЬЧИЛНА

16

ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН
СУУРЬ ТАВИГДАНА

17

ГАДААДЫН САЙН ТАМИРЧДЫГ
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БОЛГОЕ

18

"ХАРИЙН ДАРАНГУЙЛАЛ ОРЖ ИРНЭ"
ГЭХ АЙДСААР УЛСЫН ХӨГЖЛИЙГ
ГАЦААЖ БАЙНА!

19

ХҮНСНИЙ ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ,
ХУДАЛДААНЫ АСУУДЛЫГ
ХУУЛЬЧИЛЖ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА

20

126 ГИШҮҮНТЭЙ ПАРЛАМЕНТЫН
АНХНЫ ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРОО ОЮУТОЛГОЙН АСУУДЛААР
БАЙГУУЛАГДЛАА

22

ХУУРАМЧ ШАТАХУУНЫ ЭСРЭГ
ХУУЛИАР ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД,
ЭД ХӨРӨНГИЙГ ХАМГААЛНА

23

ПАРЛАМЕНТЫН БОДЛОГЫН ШИНЖ
ЧАНАР ҮРГЭЛЖЛЭХ УЧИРТАЙ

24

УЛСЫНХАА ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙГ
АВЧРАХ ЗАЛУУ ХҮН АМЫНХАА
ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ

25

УЛААНБААТАР ХОТЫН СОЁЛЫН
ХУВСГАЛ БУЮУ "20 МИНУТЫН ХОТ"
СЭЛБЭ ДЭД ТӨВ

26

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДОВ

27

ДЭЛХИЙН УРАНЫ НӨӨЦИЙН 14
ХУВИЙГ БҮРДҮҮЛДЭГ КАЗАКСТАН
УЛСАД АЖИЛЛАЛАА

28

АКТУАР ТООЦООЛЛЫН АШИГЛАЛТЫГ
ЭРЧИМЖҮҮЛНЭ

29

МОНГОЛ-КИРГИЗ ХОЁР ОРНЫ
НАЙРАМДАЛТ ХАРИЛЦАА ШИНЭ
ТҮВШИНД ХҮРНЭ



30 _____
УНГАР УЛСЫН ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН ОРЛОГЧ СИЛАДИЙ
ПЕТЕРИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

31 _____
НИЙСЛЭЛИЙН МАН 100 НАС ХҮРЛЭЭ

32 _____
ОНЦГОЙ БАЙДЛЫН ШИНЭ САЛБАР
АНГИ ЭНЭ ЖИЛ АШИГЛАЛТАД ОРНО

33 _____
ДҮҮРГИЙН БҮХ ЦЭЦЭРЛЭГ ОЛОН
УЛСЫН ХӨТӨЛБӨРӨӨР ХИЧЭЭЛЛЭЖ
БАЙНА

34 _____
“МИРАЛ САН”-ТАЙ ХАМТАРЧ
ДҮҮРГИЙНХЭЭ ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙГ
ШАЛНЫ ХАЛААЛТТАЙ БОЛГОНО

36 _____
МОНГОЛ УЛСЫН ШИНЭ
НИЙСЛЭЛ ХОТЫГ ИРЭЭДҮЙД
СЭРГЭЭН БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ
ЗҮЙН ОРЧИН БҮРДЛЭЭ

37 _____
УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД
“ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ
НЭЭВ

38 _____
ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ
БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БҮЮУ
УТААНЫ СОНСГОЛ

39 _____
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН “ГУРВАН
ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН ХЭСГҮҮД
АЖИЛЛАЖ БАЙНА

40 _____
21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ
“ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ
ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ
УРАГШИЛЛАА

41 _____
УРАНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР
ХУРИМТЛАЛЫН САН АРВИЖНА

42 _____
ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ
ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ЗАЛУУСЫН
ТОО 65% БУУРНА

43 _____
НИЙСЛЭЛИЙГ 14 ХОТОД ХУВААЖ,
ХОТЫН ДАРГАА ИРГЭД ӨӨРСДӨӨ
СОНГОНО





ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР НЬ ЦАГ ҮЕДЭЭ НИЙЦСЭН, **УЯЛДААТАЙ БОДЛОГО,** ХЯНАЛТЫН **ОНОВЧТОЙ МЕХАНИЗМ** ЮМ

2024 оны УИХ-ын сонгуулийн 10 дугаар тойрогт 19 нам эвслийн 90 нэр дэвшигчтэй өрсөлдөж 6 гишүүний нэгээр сонгогдож парламентад төлөөлөн суух болсон маань Чингэлтэй дүүргийнхээ хөгжил цэцэглэлтийн төлөөх сэтгэл, зүтгэл маань үнэлэгдэж итгэл хүлээлгэж болох хүн гэж үзсэний илрэл болов уу.

Боловсролын салбарын хөгжил нь улс орныг урагш алхах гол хүч учраас дүүргээсээ өөрчлөлтийг эхлүүлэх нь зүйтэй гэж үзэн “Ялгааг арилгая” төслийг санаачилсан нь өнөөдөр үр шимээ өгч Чингэлтэйн 38 цэцэрлэг олон улсын хөтөлбөрт шилжжээ. Ингэснээр монгол хүүхдүүд аль ч улсад шилжин суралцахад хөтөлбөрийн ялгаа, тоглоом хэрэгслийн дутагдалгүй болж байна.

Эдийн засгийн хүндрэлтэй энэ үед бид төсөв, мөнгө ярьсаар Боловсролын салбараа гээгдүүлсэнд санаа зовниж Хамтарсан Засгийн газрын шинээр томилогдсон Ерөнхий сайд Г.Занданшатарт “Хотын төвийн болоод захын сургууль хоорондын ялгааг арилгаарай” хэмээн үг дайв. Салбарын доройтол энэ жилийн ЭЕШ-ыг завхруулсан үйл явдлаар төгсгөл болох учиртай тул зарим гишүүдийн хамт Боловсролын сайдыг огцруулах шаардлагыг ч мөн хүргүүлээд байна. Салбарын хөрөнгө оруулалт буурч, нийслэл орон нутгийн хүүхдүүдийн дунд ялгаатай байдал бий болсон нь хамгийн том асуудал болоод байгаа юм. Гэтэл улстөрч хүн хувьдаа сургуультай байх нь битгий хэл хүүхдүүдээ улсын сургуульд суралцуулдаг байх ёстой гэж боддог. Нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд залуусын оролцоо бага, тэдний оролцоог хангах асуудал сул хэвээр байгааг НҮБ-ын Хүн амын сангийн судалгаанд онцолж энэ чиглэлд анхаарч ажиллахыг бидэнд зөвлөсөн. Залуу гишүүний хувьд улсынхаа ирээдүйн хөгжлийг авчрах хүн амынхаа хөгжлийг дэмжихэд манлайлж ажиллана.

Яахын аргагүй манай зарим салбар 20-р зуундаа гагцхиаад байгаа нь бодит үнэн.

ТЭЦ-3 дулааны цахилгаан станц болон Дүнжингаравын замд гарсан дэлбэрэлтээс үүдсэн хохирол эд хөрөнгөнөөс гадна амь насны золиостой. Өнөөдөр хэн ч хариуцлага хүлээсэнгүй. Түлэгдсэн иргэд, алба хаагчдад даруй арьс нөхөн суулгах шаардлагатай байсан ч бидэнд тэр хэмжээний нөөц байгаагүй. Улс орон даяараа цусны хомсдолд орчихсон.





Тийм ч учраас мэргэжлийн үйл явц талаасаа, шинжлэх ухаан талаасаа маш нарийн судалгааны үндсэн дээр Эрхтэн, эд эс шилжүүлэх суулгах, Цусны донорын тухай гэсэн тусдаа бие даасан хууль боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж байна. Оновчгүй бодлого, уялдаагүй бүтэцтэй байгаагийн үр дагавар. Түүнчлэн Онцгой байдлын алба хаагчдын тоног хэрэгсэл яг л хүүхдийн тоглоом шиг. Өнгөрсөн жил Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн салбар анги байгуулахад дүүргийн төсвөөс 5 тэрбум төгрөг төсөвлөж батлуулаад хүн амын төвлөрөл ихтэй 12-р хороонд барилгын ажлыг эхлүүлсэн. Энэ жилдээ багтаж ашиглалтад орно. Эрчим хүч байхгүй газар бид хэрхэн үйлдвэрлэл эрхлэх билээ. Салбарын бүтцээ тодорхой болгохын тулд олон

“толгойгоо” нэгтгэж эрчим хүчний зохицуулах хороог салбар яаманд өгөхийг шийдвэр гаргагчдад санал болгоод байгаа.

Эрчим хүч, цэвэр усны нөөц, дэд бүтцийн хангамж, газар зүйн тогтоц хүчин чадлын хувьд Улаанбаатар хот дээд цэгтээ хүрч, үнэнд гүйцэгдчихээд байгаа тул хөдөө орон нутгаа хөгжүүлэх зайлгүй шаардлага үүссэн. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг анхнаасаа дэмжиж ирсэн хүний нэг нь би. 30, 40 км-ийн зайтай 500-600 хүн амтай сумдад бид сургууль, соёлын төв барьж өгч байна. Энэ хэр оновчтой вэ? Хөрөнгө оруулалтыг эрэмбэлэхийн тулд сумдыг цөөлөх, нөгөөтэйгүүр нэгтгэх томруулж бүтцийн шинэчлэл хийх хэрэгтэй. Энэ чиглэлээр Монгол Улсын Засгийн газар Бүсчилсэн хөгжлийн бодлогыг

боловсруулж бүсийн төвүүдэд Анхдугаар зөвлөгөөнүүдийг хийгээд байгаа.

“ Манай улс 330 сумтай. Гуч, дөчин километрийн зайтай, 500-1000 хүн амтай сумдад 500-600 хүүхдийн хүчин чадалтай сургууль барьж өгч байна. Энэ хэр оновчтой шийдэл вэ? Хөрөнгө оруулалтыг эрэмбэлэхийн тулд сумдыг цөөлөх, нөгөөтэйгүүр нэгтгэн томруулж бүсчилсэн хөгжлийг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай. Тиймээс цөөхөн хүн амтай, ойрхон сумдыг нэгтгэж нэгийг нь статусыг сумаар нь үлдээгээд бусдыг нь тосгон болгон өөрчлөх замаар шинэчлэл хийх нь зүйтэй.

Энэ том эхлэлийн чухал хэсэг нь Эртний нийслэл Хархорум хотоо сэргээн босгох Монгол Улсын Ерөнхийлөгч УХүрэлсүхийн санаачилгыг “амилуулах” ажил хийгдэж байна. Миний бие 21 гишүүний хамт “Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай” хуулийг боловсруулж нэгдүгээр сард батлуулснаар уг бүтээн байгуулалтыг хийх эрх зүйн орчин бүрдсэн юм.

Аливаа шинэчлэл эрх зүйн орчны таатай нөхцөл бүрдсэнээр бодит болох боломж нь нээгддэг. Энэ нь ард түмнээ төлөөлөн суугаа 126 гишүүний үндсэн үүрэг. Та бүхэндээ дуулгах таатай

мэдээ бий. Бид ард иргэдээ эд хөрөнгөөр, эрүүл мэнд, амь насаар хохироож буй олон асуудалд практикч болон шинжлэх ухаанч байдлаар хандаж Хүнсний тухай хуулийн өөрчлөлт, “Хуурамч шатахууны эсрэг”, “Суррон, скүүтерийн хэрэглээ”-г зохицуулах зэрэг хэд хэдэн хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

Ирэх жил кибер аюулгүй байдал, Үндэсний өв соёлыг хамгаалах, уламжлалыг дэмжих чиглэлд төвлөрч ажиллахаар төлөвлөж байна.

Танк, хүнд машин механизм, онгоцоор улс орны аюулгүй байдлыг хамгаалдаг цаг үе

улирч нисгэгчгүй төхөөрөмж буюу дроны эрин үед бид амьдарч байна. Технологид суурилсан улс орны аюулгүй байдлыг хамгаалах нэг хэсэг нь нисгэгчгүй дрон удирддаг цэрэгтэй болох явдал тул бид энэ чиглэлийн бодлого, тогтолцоотой болох шаардлагатай.


Мөн УИХ-аас баталж буй хууль бүр “Хүн төвтэй” үзэл санааг эрхэмлэсэн, хүний эрхийг зөрчих бус дээдэлсэн байхыг эрхэм зорилгоо болгон батлагдсан хуулиудыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. Би үүний нэгэн эд эс болж буй.

Б.Цэцэгсүрэн




БҮСЧИЛСЭН БОДЛОГООР МОНГОЛ УЛСЫН ЦУСНЫ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛНЭ

Цусны донорын тухай бие даасан хууль
Өргөн барьсан огноо: 2025.03.31



Монгол улс Донорын тухай хуулиар цусны болон эд, эс, эрхтний донорын асуудлыг зохицуулж байв. Олон нийтэд цусаа өгөхийг уриалах боломжтой ч эд, эс эрхтний донор болохыг ухуулах нь хүнд сэдэв тул хоёр тусдаа хуулиар зохицуулах шаардлага үүссэн юм. Мөн хүн ам өсөн нэмэгдэхтэй зэрэгцэн цусны

хэрэглээ нэмэгдэж, ялангуяа хөдөө орон нутагт цусны нөөц асар дутагдалтай байгаа нь, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Цусны төв”-ийг сайжруулж, халдварт өвчин тархаахгүйгээр ажиллах нөхцөл бүрдсэн нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах үндэс болсон юм.




Цусны донорын тухай хууль батлагдсанаар,

- Цусны донорын сургалт, сурталчилгаа сайжирч, орон нутагт ахиц дэвшил гарна
- Цусны донорын нийгмийн халамж, урамшуулал сайжирч, тоо нь нэмэгдэх боломжтой
- Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэнэ

Монгол Улсад **170** мянган цусны донор бий.

Тэд **1** удаа цус өгөхөд
500 мянган хүний эрүүл мэнд, амь
насыг аварч, амьдрал бэлэглэдэг.



УИХ-ын гишүүн
Н.Батсүмбэрэл:

Том хэмжээний гамшиг болоход 100 хүний цусыг нэг дор нөхөх хэмжээний нөөц манайд байхгүй. Тиймээс Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уяж, Монгол Улсын цусны нөөцийг бүрдүүлэх том зорилгоор уг хуулиа боловсруулав.

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭЛХИЙН ЖИШИГТ НИИЦҮҮЛНЭ


Эрхтэн, эд, эс шилжүүлэх суулгах тухай бие даасан хууль

Өргөн барьсан огноо: 2025.03.31



Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд маш хурдацтай хөгжиж байна. Анагаах ухааны гайхамшигтай үр дүнгүүд иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох, амьдруулах зэргээр хүсэл мөрөөдлийг нь биелүүлдэг болжээ.

Эрхтэн, эд, эс гэдэг нь 3 тусдаа ойлголт бөгөөд эрхтэн нь элэг, бөөр гэх мэт хүний биеийн үндсэн эрхтнүүд бол эдэд нүдний торлог, арьс зэрэг хэсгүүд багтана. Харин эсийн хувьд үүдэл эс, эр бэлгийн эсийг нөхөн үржихүйд хэрхэн ашиглахыг хамааруулж эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг стандартыг сайжруулсан өөрчлөлтийн хамт хийгээд байна.



Манай улс анх 2006 онд бөөр шилжүүлэн суулгаснаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ эхэлсэн. Үүнээс хойш 2011 онд элэг, 2014 онд ясны чөмөг, үүдэл эс, 2018 онд элэг шилжүүлэн суулгах баг тус байгуулагдаж шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна.

Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл батлагдсанаар:



- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж, эмчилгээний аргууд улам нэмэгдэж, хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
- Нийгмийн даатгал төлдөг, эс төлдөг эсэхийг үл хамааран тайтгарлын зардал өгөхөөр тусгасан. Амьгүй донорын гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлэн олгох болон оршуулгын зардлын хэмжээг тооцсон мөнгөн дүн юм.
- Мөн иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх, гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасаж, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
- Түүнээс гадна эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинө.

АМЬ НАСАНД ХАЛТАЙ СКУУТЕР, СУРРОНЫ ХЭРЭГЛЭЭГ ХУУЛЬЧИЛНА

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай
Өргөн барьсан огноо: 2025.07.03



Улаанбаатар хотод өдөрт дунджаар 700-800 мянган тээврийн хэрэгсэл авто замын хөдөлгөөнд оролцохын хажуугаар сүүтер, сурроноор нас насны хүмүүс ямар ч зохицуулалтгүйгээр замын хөдөлгөөнд оролцож байна.



Манай улсад импортоор орж ирсэн суррон,
СКУУТЕРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 онд **1050**
2023 онд **8157**
2024 онд **16783**

Ялангуяа **18** нас хүрээгүй хүүхдүүд суррон, сүүтерээр замын хөдөлгөөнд оролцож, унаж бэртэх, явган зорчигч, автомашин, унадаг дугуй, мотоциклтэй мөргөлдөж зам тээврийн осолд өртөх, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол гарах нь нэмэгдэж байна.

2019-2024 он, 2025
оны эхний 4 сарын
байдлаар цахилгаан
дугуй, скүүтер, мопедоос
үүдэлтэй
985 осол,
5 хүн амь насаа
алдсан хэрэг
бүртгэгджээ.



Учир нь эдгээр хэрэгслүүдийн ангилал, тодорхойлолт, жолоочийн эрх, үүрэг, хариуцлага хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулинд тодорхой зохицуулалтгүй байгаа учраас хууль цаг үеэсээ хоцрохгүй байх Гурван төгөлдөршил бодлогын хүрээнд бид Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулаад байна.

Цахилгаан скүүтерийг **16**-гаас дээш,
цахилгаан дугуйг **18**-аас дээш насны хүн
жолоодно хэмээн уг хуулийн
төсөлд тусгажээ

Хуулийн төсөлд:

- Цахилгаан скүүтер, цахилгаан дугуй, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл гэсэн тээврийн хэрэгслийн ангиллыг шинээр тодорхойлж, жолоодох насны хязгаар, тээврийн хэрэгслийн техникийн дээд хурд, зорчихыг зөвшөөрсөн замыг зохицуулсан.
- Цахилгаан скүүтер, цахилгаан дугуй жолоодож, замын хөдөлгөөнд оролцогчийн эрх, үүрэг, жолоочид хориглох зүйлсийг тусгасан.
- Цахилгаан скүүтерийн хөдөлгүүрийн хүч чадал, техникийн дээд хурд, тээврийн хэрэгслийн жин, тээврийн хэрэгслийн тоноглол зэргийг агуулсан цахилгаан скүүтерийг ашиглах замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлагыг тусгасан.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад “Нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийн үйлчилгээ үзүүлэгч” нь зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх, мөн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүргийг шинээр тодорхойлжээ.

ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ ТАВИГДАНА

Хууль тогтоомжийн тухай хууль
Батлагдсан огноо 2025.06.27



УИХ-ын чуулганы 2025 оны хаврын чуулганаар хүн төвтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Ажлын хэсгүүдийн санал дүгнэлт, боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Тухайлбал, хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тавигдах ёстой. Хууль бүтээх сэтгэлгээг өөрчлөхгүйгээр эрх зүйн хөгжилд хүрэх боломжгүй. Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой.

“ Өнөөгийн Монгол Улсын нийгмийн харилцааг 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан зарчим, үзэл санаа, түүнд нийцүүлэн боловсруулсан хууль тогтоомжоор зохицуулж байна.



Д.АМАРБАЯСГАЛАН

УИХ-ын дарга

Өнөөдөр хууль ба журмын зохист харьцаа алдагдсаны улмаас хууль биш, харин журам ноёлж байна. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг ирсэн.




Н.БАТСҮМБЭРЭЛ

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн гишүүн

Хуулийн төсөл боловсруулахдаа тухайн төсөл нь анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийнхөө үзэл баримтлал, агуулгад нийцсэн, олон нийтийн саналыг тусгасан, холбогдох тайлбар, үндэслэлийг танилцуулгад тусгадаг байхаар өөрчлөн найрууллаа.

ГАДААДЫН САЙН ТАМИРЧДЫГ МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БОЛГОЁ

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
Батлагдсан огноо 2025.07.09



Дэлхийн улс орнууд спортоор дамжуулан үндэсний үнэт зүйл, амин чанар, бахархлаа улам бэхжүүлж, хүүхэд, залуучуудыг спортын нөлөөгөөр хүсэл мөрөөдөлдөө тууштай, тэвчээр хатуужилтай, зөв төлөвшилтэй болгоход нь ихээхэн анхаарч байна. Түүнчлэн олимпын үзэл санааг түгээн дэлгэрүүлж, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс амжилт гаргах магадлалтай Гадаадын иргэнийг өөрийн улсын нэр дээрээс оролцуулах зохицуулалт дэлхийн улс орнуудад ч хүчтэй өрнөж буйг хэлэх нь зүйтэй!

Монгол Улс олимпын түүхийн хугацаанд жүдо, чөлөөт бөх, бокс, буудлагын спортоор медаль авсан байдаг. Цаашид олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын бусад төрөл ялангуяа багийн спортыг эрчимтэй хөгжүүлэх, хүний нөөцөө бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхэд тамирчид, спортын холбоод, клубүүд, зүтгэлтнүүдийн оролцоо, салбарын эрх зүйн орчин нэн чухал байгаа юм. Иймд миний бие УИХ-ын нэр бүхий гишүүдийн хамтаар дээрх хуулийн төслийг боловсруулан өргөн барьсан юм.

Хуулийн төсөлд:



- “Олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болох агуулга;



- Олимпын төрлийн спорт болон багийн спортыг хөгжүүлэх зорилгоор гадаадын дасгалжуулагч, мэргэжилтэнг урьж ажиллуулбал ажил олгогчийн төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг тусгав.

“ХАРИЙН ДАРАНГУЙЛАЛ ОРЖ ИРНЭ” ГЭХ АЙДСААР УЛСЫН ХӨГЖЛИЙГ ГАЦААЖ БАЙНА!

Монгол Улсад гадаадын ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тоог тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төсөл
Өргөн барьсан огноо 2024.12.19



Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн зөрүүтэй байдал нэмэгдэж, ажиллах хүчний хомсдол нүүрлэсэн нь Монгол Улсыг “том сорилт”-ын өмнө авчирч буй. Тухайлбал, Монгол Улсад 1993-2006 оны хооронд төрөлтийн дундаж үзүүлэлт эрс бага байсан нь дотоодын ажиллах хүчний хомсдолыг үүсгэж, энэ хомсдол 2030 он хүртэл үргэлжлэх судалгаа гарсан. Тиймээс уг төлөвийг харгалзаж,

дээрх хуулийн төслийг миний бие нэр бүхий гишүүдийн хамтаар өргөн мэдүүлсэн билээ.

Түүнчлэн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын “Төрийн бүтээмжийн сэргэлт” дэх Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны

төлбөрийг 50% хөнгөлөх, ингэснээр дотоодоос хангах боломжгүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломж бүрдүүлсэн байх үр дүнд хүрэхээр тооцсон байдаг. Энэ хүрээнд бизнес эрхлэгч, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг ажиллах хүчний хомсдолд орсныг цаг алдалгүй таслан зогсоох зорилгоор уг хуулийн төслийг өргөн мэдүүлснийг хэлэх нь зүйтэй!



Хуулийн төсөлд:

Уул уурхай, газрын тос олборлох үйл ажиллагаанаас бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй бөгөөд энэ хугацаанд ажил олгогчийг гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг тусгав.

ХҮНСНИЙ ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ХУДАЛДААНЫ АСУУДЛЫГ ХУУЛЬЧИЛЖ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн барьсан огноо 2025.07.04



Хүнсний баталгаат байдал, ханган нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулж, хэрэглэгчдийн хүртээмжтэй, шим тэжээллэг, чанартай, баталгаат хүнсээр хангах зорилгоор 13 жилийн дараа ХҮНСНИЙ ТУХАЙ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хүнсний тухай, аюулгүй байдлын тухай хуулиудаар зохицуулагдаагүй хүнсний тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, гадаадын тусламжаар хүнс авах асуудал өнөөдрийн хүнсний аюулгүй байдалд сөрөг үр дагавруудыг бий болгоод

байна. Үүнээс гадна хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хариуцлагыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг төрийн бодлогод тусгах, эрүүл хүнсний хэрэглээг дэмжих сургалт сурталчилгааны асуудлыг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;
2. Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, гадаад, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна;
3. Хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна;
4. Хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаа сайжирна;

126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо Оюутолгойн асуудлаар байгуулагдлаа

Хуулийн нэр: УИХ-ын Хянан шалгах
Түр хороо байгуулах тухай тогтоолын төсөл
Өргөн барьсан огноо: 2025.06.27



УИХ-ын гишүүн О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл нарын нэр бүхий 89 гишүүний өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг чуулганы /2025.07.02/-ны өдөр хэлэлцэж, гишүүдийн 72.9 хувийн саналаар баталсан юм. Тогтоолын төсөлд “Оюутолгой

стратегийн ач холбогдол бүхий бүлэг ордын хил заагт Канад Улсын хөрөнгө оруулалттай “Онтрэ” ХХК-ийн эзэмшилд буй “ШИВЭЭ ТОЛГОЙ” болон “ЖАВХЛАНТ” ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хамаарч байна. Уг хоёр тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах газрын хэвлийн баялгийг ашиглахад Монгол

Улсын эрх ашгийг хангахтай холбоотой гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй ирсэн байна. Харин шинэ 126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо Оюутолгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр ийнхүү УИХ-ын тогтоол амжилттай батлагдлаа.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөлд

- Парламентад суудалтай **5** намын намын **89** гишүүн гарын үсэг зурлаа.



- Түр хороо үндсэн 2 чиглэлээр ажлаа 6 сарын дотор явуулна.

Нэг

Оюутолгой стратегийн бүлэг ордын хил заагт албан ёсоор орсон Канадын хөрөнгө оруулалттай “Онтрэ” компанийн эзэмшилд байгаа Шивээ толгой, Жавхлант 2 лиценз дээр Монгол Улсын эрх ашгийг хангуулж шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийх, холбогдох санал дүгнэлт гаргаж хяналт шалгалтыг хийнэ.



Хоёр

Оюутолгой төслийн зээлийн хүү бууруулах дээр ажиллана. Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр 7 жил тутам зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх эрхээ бид нар хэрэгжүүлж өнөөдөр 11,1% байгаа зээлийн хүүг олон улсын жишигт дөхүүлж зайлшгүй бууруулах ёстой.



Хянан шалгах түр хорооны ажлын үр дүнд

- Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр **7** жил тутам зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх эрхээ хэрэгжүүлнэ.



- Өнөөдөр **11,1%** байгаа зээлийн хүүг бууруулах боломж үүснэ.

- Ноогдол ашгаа **8-10 жил, 12, 13** жилээр наашлуулах цаашлаад бараг **12, 13** жилээр наашлуулах боломж гарна.



Хуурамч шатахууны эсрэг хуулиар иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаална

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Өргөн барьсан 2025.06.19



2015 онд онцгой албан татварын хувь хэмжээг 400 мянган төгрөг, дизель түлшийг 520 мянган төгрөг болгон тогтоосноос үүдэж, завсрын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, уг бүтээгдэхүүнд онцгой албан татвар, тусгай зөвшөөрөл шаардахгүй байгаа нь хуурамч шатахуун үйлдвэрлэх гол шалтгаан болсон юм. Хольцтой шатахуун хэрэглэснээр тоног төхөөрөмж амархан эвдэрч, хоёр жилийн дотор хэрэглээнээс гарахаас гадна машины хар утаанаас үүдэж ялангуяа жирэмсэн эх, хүүхдүүдийн амьсгалын эрхтэн гэмтэж байгааг судалгаа харуулдаг.

Шударгаар татвараа төлөөд явж байгаа олон аж ахуй нэгжүүдийн эрх ашиг хөндөгдсөн хууль бус үйлдэлд цэг тавьж бидний хэдэн нөхөд онцгой албан татварын тухай хуульд газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дайван бүтээгдэхүүн дээр татвар тогтоох заалтыг нэмж орууллаа.

Ингэснээр хуулийн цоорхойг ашиглан гаараад буй үйлдэл зогсож агаарын бохирдол 30 хувиар буурах том нөлөөг үзүүлэхээс гадна иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэнд хамгаалагдаж, татвараас зугтаах явдал буурч, төсөвт нэмэр болох юм.



Тээврийн хэрэгсэл нь агаарын бохирдлын хоёрдогч том эх үүсвэр бөгөөд утааны

28.9

хувийг үүсгэдэг

Нийслэлийн хэмжээнд

712.992

тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байна



Парламентын бодлогын шинж чанар **үргэлжлэх учиртай**

УИХ-ын Дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл 2024.08.23-ны өдөр батлагдав



126 гишүүнтэй парламентын гишүүдээс өргөн мэдүүлж буй анхны хуулийн төслийг 5 гишүүний хамт боловсруулж 2024 оны наймдугаар сарын 23-ны өдөр эцэслэн батлуулав.

Уг хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын

Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн парламентын тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмж өөрчлөхөөр болсон юм. Ийнхүү бодлогын шинж чанар, эхэлсэн төсөл хөтөлбөрүүдийг орхилгүй цаашид хэрхэхийг заавал хэлэлцэн шийдвэрлэхээр хуульчилж байна.

УИХ 2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж

“Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна” гэж тусгав.

Ингэхдээ 2024 оны сонгуулийг холимог тогтолцоогоор буюу гишүүнийг тойргоос,



78

48 -ыг нь хувь тэнцүүлэх аргаар буюу намын жагсаалтаар сонгосноор түүхэндээ анх удаа

126 гишүүнтэй парламентыг бүрдүүлэв.

Улсынхаа ирээдүйн хөгжлийг авчрах залуу хүн амынхаа **хөгжлийг дэмжинэ**

УИХ-ын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах ажлын хэсэг НҮБ-ын Хүн Амын сан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуудын яамтай хамтран “Залуучуудын нөхцөл байдлын шинжилгээний тайлан”-г олон улсын байгууллагуудад танилцуулж, зөвлөмж авлаа.

Боловсролын салбарт хөрөнгө оруулалт буурч, нийслэл орон нутгийн хүүхдүүдийн боловсролын ялгаатай байдал бий болсон нь гол асуудал болж байна. Харин залуусын ажилгүйдэл өндөр хувьтай, сургалт, хөдөлмөрийн зах зээл хоорондын уялдаа сул байна. Нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд залуусын оролцоо бага, тэдний оролцоог хангах асуудал сул хэвээр байгааг судалгаанд онцолж энэ чиглэлд анхаарч ажиллахыг зөвлөв.

Уг судалгааны үр дүн, зөвлөмж нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, бодлого, хөтөлбөрүүдийг боловсронгуй болгоход чухал нөлөөтэй эх сурвалж болж байна.

УИХ-ын залуу гишүүний хувьд Монгол Улсын ирээдүйн хөгжлийг авчрах залуу хүн амынхаа хөгжлийг бодлогоор дэмжихэд манлайлж ажиллана.



Монгол Улс 2023 оны байдлаар
Залуучуудын хөгжлийн индекс

0,770
үзүүлэлтээр **181** улсаас
61 -т эрэмблэгдэж дунджаас
дээгүүр ангилалд багтаж
байна.



НҮБ-ын Хүн амын сангийн
Ази, Номхон далайн
бүсийн дэд захирал доктор
Александр Саша Бодироза:

Дэлхийн 1.8 тэрбум
залуучуудын дийлэнх
нь хөгжиж буй орнуудад
амьдарч байгаа өнөө
үед тэднийг хөгжлийн
зорилгод түнш болгон,
жинхэнэ утгаар
оролцуулах нь тогтвортой
хөгжил, шударга нийгмийн
амин сүнс юм.

Улаанбаатар хотын соёлын хувьсгал “20 минутын хот” Сэлбэ дэд төв



Сэлбэ дэд төвийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл Сүхбаатар дүүргийн 14, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороонд хэрэгжиж буй. Энэ хүрээнд Сэлбэ дэд төвийг барих газар чөлөөлөлтийг 2024 оны дөрөвдүгээр сард эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар эхний ээлжийн хоёр багц тендерийн бүтээн байгуулалт болох 4400 айлын орон сууцыг 6 буудал, Оргил худалдааны төв орчмын 25.6 га талбайд барих юм. Сэлбийн бүтээн байгуулалтын орчимд хийгдэж буй орчимд өнөөдөр ерөнхий боловсролын 3 сургууль хичээллэж байгаа. Үүн дээр нэмээд гадаад хэл, техник, спортын төрөлжсөн хөтөлбөртэй 3 сургууль, 5 цэцэрлэг шинээр барихаар төлөвлөөд байна.



Сэлбэ дэд төв бий болсноор:

- Стандартад нийцсэн 12 мянган айлын орон сууц баригдана.
- Иргэд 20 минутын дотор нийгмийн бүхий л үйлчилгээг авдаг болно.
- Хотын хэт төвлөрөл буурч, агаарын бохирдол 22% багасна.
- Хотын эдийн засаг тэлж, ажлын байр бий болох юм.



УИХ-ын гишүүн
Н.Батсүмбэрэл:

Улаанбаатар хотод хийгдэж буй соёлын том хувьсгал юм. 4 уулын дунд 200 гаруй жил оршин буй нийслэл хот маань хамгийн бага хэсэгтээ л гэхэд 100 жилийн газрын элэгдэлтэй болчихоод байгаа. Айлыг олон удаа дулаалж чадахгүй. Утаа, үер, ус, түлш, дулаан гээд бүх асуудлыг ганц замаар л шийднэ. Энэ бол барилгажилт.



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар:

Сэлбийн бүтээн байгуулалт III, IV хороолол дээр “Өнөр” хорооллыг нэмсэн дайны том бүтээн байгуулалт болно. Өөрөөр хэлбэл нийтдээ 13 мянган айлын үйлчилгээтэй орон сууцны цогц төсөл болох юм. Бид энэ ажлыг 24 сарын хугацаанд барьж дуусгана.

Улстөрийн шинжлэх ухааны холбооны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр сонгогдлоо



Монголын Улс төрийн шинжлэх ухааны холбооны их хурал 2025 оны дөрөвдүгээр сарын 24-ний өдөр эрдэмтэн судлаач, салбарын экспертүүд, МУИС-ийн төгсөгчдийн дунд болж миний бие тус холбооны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр сонгогдлоо. Тус холбоо нь Монгол Улсад Улс төрийн шинжлэх ухааныг

хөгжүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, судалгаанд суурилсан төрийн бодлого төлөвлөлтийг дэмжих зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг бөгөөд Олон Улсын Улс төрийн шинжлэх ухааны холбоон дахь гишүүнчлэлээ сэргээж, тэргүүлэх эрдэмтэдтэй хамтран ажиллахаар зорив.

МУИС-ийн профессор Ц.Ганболд 2005 онд Олон Улсын Улс төрийн шинжлэх ухааны холбооны жинхэнэ гишүүн болж 2006 онд Японы Фукоако хотод болсон тус холбооны XX их хуралд Монгол Улсаас анх удаа төлөөлөгчөөр оролцож байсан бол 2012 онд Монгол Улс тус холбоонд элссэн түүхтэй.



1948 онд ЮНЕСКО-ийн санаачлагаар улс төрийн шинжлэх ухааны асуудлаар олон улсын бага хурал Парист болсон явдал нь Францад төдийгүй бусад орнуудад улс төрийн шинжлэх ухааны судлах зүйлийн хүрээ нэг талаас нарийсан гүнзгийрч, нөгөө талаас цэгцрэн хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн.

Дэлхийн ураны нөөцийн 14 хувийг бүрдүүлдэг Казакстан Улсад ажиллалаа

УИХ-ын дэд дарга
Б.Пүрэвдоржоор ахлуулсан
УИХ, ЗГХЭГ-ын ажлын
хэсгийн бүрэлдэхүүнд багтаж
Казахстан Улсад томиллоотоор
ажиллахдаа дэлхийн ураны
батлагдсан нөөцийг 14
хувийг бүрдүүлдэг шилдэг
туршлагатай нь танилцав.

1996 оноос Францтай хамтран
уран олборлолт хийж байгаа
бөгөөд улсынхаа өмнөд хэсэгт
байрлах Торткудукийн бүлэг
ордоос Катко, КазАтомПром
компани газар доогуур
уусган олборлох аргаар уран
олборлож, түүнийгээ эцсийн
бүтээгдэхүүн буюу “саарал
нунтаг” болгон гарган авч, түлш
боловсруулах үйлдвэрүүдэд
нийлүүлдэг байна.

Уран олборлож буй газар ард
иргэддээ ээлтэй байдлаар
хэрхэн үйл ажиллагаа явуулдаг
болохыг нүдээр харсан нь
уг томилолтын олз, итгэл
үнэмшлийн баталгаа болов.



УИХ-ын гишүүн
Э.Батшугар:

Манай улс эрчим хүчний 20 хувийг
хоёр хөршөөсөө импортолдог.
Уран олборлолт эхэлснээр
цөмийн цахилгаан станцтай болох
боломжтой. Дэлхийн зах зээлд
өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа
ураны зах зээлд Монгол Улс орох
нь эдийн засгаа солонгоруулах,
долларын орлогыг нэмэгдүүлэх,
валютын ханшийг сулруулж,
төгрөгийн ханшийг чангаруулах
эерэг өөрчлөлтүүд олон гарна

Тухайлбал

- Ажиллах хүчний 90 хувь нь Казак иргэд, мэдээж орон нутгаас олон байгаа,
- Далд уусган олборлох арга хэрэглэдэг учраас ил, задгай гол, нуур бохирдуулах, тэндээс ус хэрэглэх шаардлагагүй. Гол, ус ч харагдсангүй.
- Улс, муж (аймаг), сум (тосгон)-д татвар болон бусад хэлбэрүүдээр хөрөнгө оруулалт хийдэг ажээ.

АКТУАР тооцооллын ашиглалтыг эрчимжүүлнэ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, тус салбарын тогтолцоог оновчтой болгох талаар санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллалаа.

Хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлгийн дүнд дараах шийдлүүдэд анхаарч ажиллахыг холбогдох яамны хүмүүст санал, зөвлөгөө өглөө.

Эрүүл мэндийн байгууллагын бодит нөхцөл байдал тулгуурлан актуар тооцооллыг эрчимжүүлэх, нэхэмжлэлийн хяналтын үйл явцыг сайжруулах, оновчтой болгож цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авах, иргэд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүндрэл, чирэгдэлгүй байхаар санхүүжилтийн хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.



УИХ-ын гишүүн
Т.Мөнхсайхан

Хуулийн хэрэгжилтийн үр дүнд хөнгөлөлттэй эмийн чирэгдэл багасаж, хүртээмж 58.8 хувиар өссөн ч цар тахлын үеэр ЭМДС-аас зарцуулсан зардлыг буцааж төвлөрүүлээгүйгээс үйл ажиллагаа нь доголдоод байгаа тул бодлогын шинэчлэл хэрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын сан 2024 онд **316 тэрбум**

51 **178** төгрөгийн өртэй гарсан. Үүний **178** тэрбум нь улсын эмнэлэгт, **51** тэрбум нь хувийн хэвшилд, мөн эм ханган нийлүүлэгч байгууллагуудад өр үүссэнийг 2025 оны төсөвт суулган, энэ оны I улиралд багтаан өр авлагыг барагдуулав.

Монгол-Киргиз хоёр орны найрамдалт харилцаа шинэ түвшинд хүрнэ



Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Киргизийн Засгийн газар хоорондын комиссын V хуралдаан 2025 оны 6 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотод болж миний бие парламентын бүлгийн гишүүдийн хамт миний бие оролцоод ирлээ.

Хуралдааны гол зорилго хоёр улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх тул бид нэн түрүүнд Монгол Улсаас нийлүүлэх мах, махан бүтээгдэхүүнд ногдуулах хорио цээрээ цуцлах хүсэлтийг тавьсан юм. Харин Киргиз Улсаас жимс жимсгэнэ, хүнсний ногоо нийлүүлэх, улмаар манай улсад хүлэмжийн аж ахуйг өргөжүүлэхэд хамтран ажиллах саналыг тавьснаар талууд хөнгөн үйлдвэрийн салбарт хамтарсан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, эцсийн бүтээгдэхүүнээ бусад зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар-Бишкек чиглэлийн шууд нислэгийг сэргээх, авто замын коридор, шинэ маршрут бий болгох, бараа бүтээгдэхүүний туршилтын тээвэрлэлтийн эхлүүлэхээр болж чадлаа.

Монгол-Киргиз хоёр улс 1992 оны 4-р сарын 22-нд дипломат харилцаа тогтоож, 33 жилийн турш бүх салбарт хамтран ажилласнаар худалдааны эргэлт 8 сая ам,долларт хүрчээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров нар “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурж байв.

Унгар Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч **Силадий Петерийг** хүлээн авч уулзлаа



Ойн хүрээнд “Унгар Монгол Улсын дипломат харилцаа 75 жил” фото зургийн үзэсгэлэн, “Сэтгэлд дотно Төв Ази” хэмээх баримтат киног толилуулах, Унгар, Монгол, Австрали, Англи улсын хамтарсан Бат хааны 1242 оны Эстергом хотын бүслэлтийн тухай өгүүлсэн уран сайхны киног нээх, археологийн шинэ малтлага хийх, Монгол болон Унгарт Эрдэм шинжилгээний хамтарсан хурлууд зохион байгуулах, хууль цаазын түүхийн

УИХ дахь Монгол-Унгарын парламентын бүлгийн даргын хувиар Унгар Улсын Засгийн газрын Үндэсний бодлого хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын орлогч Силадий Петерийг хүлээн авч уулзан Монгол Улс, Унгар Улс дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хийгдэх ажлууд болоод цаашид соёл, боловсрол, аялал жуулчлал, шинжлэх ухааны салбаруудад хамтран ажиллах, хоёр улсын парламентын бүлэг хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцлоо.



талаарх судалгааг эхлүүлэх, Унгарын бараа бүтээгдэхүүнийг Монголын бизнесийн салбарын төлөөлөгчдөд танилцуулах бизнес уулзалтуудыг зохион байгуулах ажлууд үргэлжилж байна.



Унгар улс нь Дархан хотод **Мах боловсруулах үйлдвэр**, Хархоринд **гурил тэжээлийн үйлдвэрийг** барьж өгсөн түүхэн гавьяатай.

70-аад жилийн хугацаанд
2000 гаруй монгол оюутан
Унгар улсад суралцжээ

Нийслэлийн МАН 100 нас хүрлээ



Нийслэлийн МАН-ын 100 жилийн ой энэ онд тохиож байна. Ойн арга хэмжээний хүрээнд 6-р сарын 22-ны өдөр 10-р тойрогт МАН-аас сонгогдсон гишүүд бид Чингэлтэй дүүргээсээ салбар бүрт манлайлж, идэвх зүтгэл гарган ажиллаж, хөдөлмөрлөж яваа намын хорооны гишүүд, дэмжигчиддээ хүндэтгэл үзүүлж “Хүндэт тэмдэг”-ийг гардууллаа.

Нийслэлийн МАН-ын түүх Улаанбаатар хотын түүхтэй нэг цэгт уягддаг тул 100 жилийн хугацаанд Улаанбаатар хотынхоо хөгжил, цэцэглэлт, иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэхийн төлөө бид хамтдаа тууштай зүтгэж, ирээдүй 100 жилийн хотын хөгжлийн бодлогыг тодорхойлон зоригтой ажилласаар байна.



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч **Х.Нямбаатар**:

Нийслэлийн намын хорооны нэгэн зууны түүх бол ээдрээт замнал, их бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийн түүх бөгөөд улсын нийслэлээ өнөөдрийн хөгжилд хөтөлж ирсэн Улаанбаатар хотын зуун жилийн түүх юм

Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг сэргээн мандуулах зорилготой **“Анхны долоо”** Монгол Ардын намыг **1921** оны гуравдугаар сарын 1-нд байгуулснаар Ази тив дэх анхны улс төрийн намаар тодорч байв

Нийслэлийн Монгол Ардын нам 1925 онд

5 үүрийн харьяанд

421

гишүүнтэй

байгуулагдаж 100

жилийн хугацаанд 78 мянга болтлоо өргөжин тэлжээ

Онцгой байдлын шинэ салбар анги энэ жил ашиглалтад орно



Монгол Улсын Онцгой байдлын газар **57** хувийн техникийн хангамж, **37-40** хувийн алба хаагчдын тусгай зориулалтын хувцас хэрэглэл, **26-28** хувийн зарлан мэдээллийн системтэй.

Миний бие Чингэлтэй дүүргийн Засаг дарга байх үедээ дүүрэгтээ онцгой байдлын салбар анги байгуулах санаачилгыг дэвшүүлж улсын төсөвт 5 тэрбум төгрөг суулгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. Энэ жил ашиглалтад орно. Өнөөдрийн байдлаар барилгын явц 75 хувьтай үргэлжилж байна.

Ангийн барилга нь 39.65м х 27м-ийн хэмжээтэй хагас зоорийн давхар бүхий барилга байхаар төлөвлөгдөж, дүүргийн 12-р хороо буюу хүн амын нягтаршил ихтэй бүсэд шуурхай хүрч ажиллах боломж ийн бүрдэж байна. Мөн тусгай зориулалтын автомашины таван граж, 4.2 метрийн өргөн, 3.2 метрийн өндөр хаалгатай, Б блоктоо албан хаагчдын зориулалттай зургаан айлын орон сууцыг шийдэж өгсөн бүтээн байгуулалт юм.

Дэлхий нийтэд тохиолддог 40 гаруй аюулт үзэгдлээс 10 орчим нь Монгол Улсад зонхилдог. Ган, зуд, хүчтэй салхи шуурга, хүн малын гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэргээр. Эдгээр аюулт үзэгдэл болсон тохиолдолд хор уршгийг нь арилгах, хариу арга хэмжээ авахад онцгой байдлын алба хүн хүч, техникийн бүрэн байдлыг хангаж оролцох ёстой ч манай улсын алба хаагчид маш хангалтгүй нөхцөлд ажиллаж байна.



Олон улсын практикт гамшгаас урьдчилан сэргийлэхэд зарцуулж байгаа нэг ам.доллар гамшгийн дараах **10-15** ам.долларыг хэмнэх тооцоолол бий.



УИХ-ын гишүүн
Н.Батсүмбэрэл:

Онцгой байдлын албан хаагчдын тоног хэрэгсэл яг л хүүхдийн тоглоом шиг. Яваад очихоор орц гарцыг чөлөөлж чадахгүй байсаар цаг алддаг. Гэтэл Улаанбаатарт хүн нэмэгдээд байдаг. Хүртээмж улам л дордоод байгаа. Төсвийг нь нэмэгдүүлж, төрөөс бодлогоор дэмжих онцгой салбар шүү

Дүүргийн бүх цэцэрлэг олон улсын хөтөлбөрөөр хичээллэж байна



Миний бие Чингэлтэй дүүргийн Засаг дарга байхдаа боловсролын байгууллагуудын ялгаатай байдлыг арилгах, тэр тусмаа хотын төвийн болон захын сургууль, цэцэрлэгийн суралцагчдын сурах орчин, багш нарын ажиллах нөхцөл ижил байх ёстой гэсэн зорилтыг тавьж “Ялгааг арилгая” төслийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн.

Дүүргийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нартай уулзах үеэр манай дүүргийн бүх цэцэрлэг олон улсын хөтөлбөрөөр хичээллэдэг болсон байна. Ингэхдээ төрийн өмчийн цэцэрлэгүүд “Steam”, “I,m break”, “Montessori” хөтөлбөрүүдээс сонгон хэрэгжүүлж байгаа аж. Мөн төвийн болон захын сургуулийн ялгааг арилгах, сурагчдын өв тэгш бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор усан сантай болох жишгийг эхлүүлж, хотын төсвийн хөрөнгөөр 23, 27, 39-р сургуульд усан сан бүхий спорт цогцолборыг барьж эхлүүлээд байна.

Чингэлтэй дүүрэг
20 сургууль,
38 цэцэрлэгтэй
бөгөөд 2024 оны аравдугаар сар
гэхэд бүх цэцэрлэгт олон улсын
хөтөлбөрийг нэвтрүүлжээ.



УИХ-ын гишүүн
Н.Батсүмбэрэл:

Хөтөлбөрүүдийн үр дүнд хүүхэд аль ч улс оронд шилжин суралцахад хөтөлбөрийн ялгаа гарахгүй, цэцэрлэгүүд тоглоом, хэрэгслийн дутагдалгүй болсон. Мөн багаасаа хүүхдүүд техник сэтгэлгээ, байгалийн ухаанд суралцах суурь бэлтгэгдэнэ.

“Мирал сан”-тай хамтарч дүүргийнхээ цэцэрлэгүүдийг шалны халаалттай болгоно



Өнгөрсөн жилийн сүүлээр БНСУ-ын “Мирал сан”-гийн төлөөлөгч Ц.Лхагвадоржтой уулзаж Монгол Улсад мэс засал хийлгэх, эмчлэгдэх боломжгүй хүүхдүүдийг сангийн дэмжлэгээр эмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, түүнчлэн хамтын ажиллагааг бусад чиглэлээр өргөжүүлэх талаар саналаа хэлэв.

Энэ үеэр БНСУ-ын Бусан хот дахь Монгол Улсын Консулын газар, БНСУ-ын Эдийн засаг, сангийн яамны харьяа “Жижиг дунд бизнес эрхлэгчдийн экспортыг дэмжих төсөл”-тэй хамтран шалны халаалтын систем суурилуулах ажлыг 2025 онд багтаан Чингэлтэй дүүргийн 56, 124, 155 дугаар цэцэрлэгт үнэ төлбөргүй хэрэгжүүлэх санаачилга дэмжигдэж Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж чадлаа.

Тус сан нь 2004 оноос өнөөг хүртэлх **300** хугацаанд гаруй Монгол хүүхэд, Хятад, Филлипин, Вьетнам, Энэтхэг тэргүүтэй **24** орны **4400** хүүхдэд БНСУ-д үнэ төлбөргүй зүрхний мэс засал хийлгэж, эмчлүүлжээ.






МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

126 ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ

2024 оны намар,
2025 оны хаврын
чуулганаар батлагдсан
гол хуулиуд болон
парламентын
онцлох ажил



МОНГОЛ УЛСЫН ШИНЭ НИЙСЛЭЛ ХОТЫГ ИРЭЭДҮЙД СЭРГЭЭН БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЛЭЭ

УИХ-ын 2024 оны намрын чуулганаар хэд хэдэн бие даасан хууль батлагдсаны нэг нь “Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль”. Хууль батлагдсанаар нүүдэлчдийн түүхэн гал голомт болсон Орхоны хөндийд суурьшсан эртний нийслэлүүдийн туурин дээр Монгол Улсын шинэ нийслэл хотыг ирээдүйд сэргээн байгуулах хууль эрх зүйн орчин бий болсон юм.

2023

УИХ-ын 07 дугаар тогтоолоор Орхоны хөндийд шинэ Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэсэн.

2024

УИХ-ын даргын 12 тоот захирамжаар уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах, бүтээн байгуулалтыг дэмжих чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан

2024

Хуулийн төслийг 2024.12.20 нд өргөн мэдүүллээ

2025

Хуулийн төслийг 2025.01.23-нд баталлаа



Г.ТЭМҮҮЛЭН

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Хотын эдийн засгийн үндэс суурь, үзэл баримтлалын хувьд түүхэн өв соёл, үнэт зүйлээ сэргээх, хадгалах асуудалд тулгуурлан олон төрөлт аялал жуулчлалыг дэмжинэ. Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бие даан хөгжих ёстой!



Н.БАТСҮМБЭРЭЛ

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн гишүүн

Энэ парламентын анхны бие даасан хууль Хархорум хотын хууль болж байна. УБ-ын ачааллыг бууруулах, хот, хөдөөгийн ялгааг багасгах, шинэ хот байгуулах энэ ажил урагшлах учиртай. Цаашдаа бодлого боловсруулах дээд байгууллага маань нүүж очих асуудал ч хөндөгдөж болзошгүй.





Н.УЧРАЛ

УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга

Ураны төсөл дээр Монголын урдаа барьдаг эрдэмтэн судлаач, орчин цагийн шилдэг хуульч, эдийн засагчидтай хамтран ажиллаж “авлига, ашиг сонирхол бүхнийг сөрж” ард нь гарсандаа сэтгэл дүүрэн байна. Нэг ёсондоо, Монголчууд Монголдоо, Монгол хүндээ үр өгөөжтэй, харилцан ашигтай, хамтран ажиллаж чаддаг, хэлэлцэн тохирч болдгийг батлан харууллаа.

Уранаа ашиглах дуусдаггүй яриаг дуусгалаа



Н.БАТСҮМБЭРЭЛ

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн гишүүн

Хуулийн өөрчлөлтөөр олон жил яригдсан, олноороо талцан маргадаг уран буюу цөмийн эрчим хүчний төсөл хөдлөх алхам нээгдэж байна. Энэ бол эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. Уран нь шинэ технологи учраас монголчууд аажимдаа хэрэглэдэг болно.

УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД “ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ НЭЭВ

2023 онд Монгол, Франц улсын Төрийн тэргүүнүүдийн харилцан айлчлалын үр дүнд, 21-р зууны эрчим хүчний гол эх үүсвэрээр нэрлэгдэж буй ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд ураныг олборлох хэлцэл үзэглэгдэх хаалга нээгдсэн юм. Үүнээс хойш Л.Оюун-Эрдэнийн тэргүүлж буй Засгийн газар Монгол Улсын шинэ 30 жилийн хөгжлийг тодорхойлж, сэргэлт авчрах 14 мега төсөлд ураны төслийг оруулж, шаардлагатай хууль тогтоомжийг шинэчилж, УИХ-аар хэлэлцэн батлуулсан. Үе үеийн эрх баригчдын дунд яригдсан ч маргаан дагуулсаар эцэст нь мартагддаг энэхүү төсөл олон жилийн дараа хэрэгжихээр болж 2025.01.17-ний өдөр гэрээг албан ёсоор үзэглэв. Энэхүү түүхэн үйл явдал нь Францын “Орона” группт ялалт болж, Монголд гуравдагч хөршийн хоёр дахь том хөрөнгө оруулалтаар дамжин хоёр улсаас “хараат бус” байх боломж бүрдэж буйг эрдэмтэд төдийгүй гаднын томоохон хэвлэлүүд онцолжээ.

УРАНЫ ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Зорилго: Ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд 68.9 мянган тонн уран үйлдвэрлэж, хүлэмжийн хийн ялгарлыг 3.9 тэрбум тонноор бууруулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ.

Санхүүжилт: БНФУ-ын Засгийн газрын шууд хөрөнгө оруулалт

Нийт төсөв	2025 онд	2026 онд	2027 онд
1.6 тэрбум\$	95.8 сая\$	108.2 сая\$	140.2 сая\$

Үр дүн: Жилд 2500тн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хугацаанд улс, орон нутагт 5.2 тэрбум\$ татвар төвлөрүүлнэ.





ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БУЮУ УТААНЫ СОНСГОЛ

Нийтийн өргөдөл, гомдлын систем petition.parliament.mn-д Батбаатарын Мөнгөнхишиг иргэний үүсгэсэн “Утааны сонсгол хийцгээе! Төсвийн зарцуулалтад хяналт, үнэлгээ хийж сайжруулцгаая” сэдэвт өргөдөлд 71 мянган иргэн гарын үсэг зурж нэгдсэнээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.1-т заасны дагуу Байнгын хүрээний эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах шаардлагыг биелүүлсэн юм.

- **2024.11.27** Утааны сонсгол хийцгээе! өргөдлийг petition.parliament.mn-д нээв
- **2025.01.15** “Агаарын бохирдол-Хүн амын эрүүл мэнд”-ийн асуудлыг хэлэлцэв
- **2025.01.22** “Зуух, түлшний хяналт, стандартын асуудал”-ыг хэлэлцэв.
- **2025.01.29** “Эрх зүйн орчин, санхүү, хариуцлага”-ыг шүүн нягтлав.
- **2025.02.03** Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ зохион байгуулав.
- **2025.04.15** Утааг багасгах шийдэл бүхий 13 заалттай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д танилцуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо шийдвэрлэв.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Монгол Улсад бүтээн байгуулалт хийгдэж байж өнөөдрийн агаар, хөрсний бохирдлоос салж, Монгол хүний амьдрах орчин сайжирна.



Ж.ЧИНБҮРЭН
УИХ-ын гишүүн

Нийслэлээс 32 мянган зуух авах тендер зарлаж, гэр хорооллын айлуудад тараахыг зогсоосон нь уг сонсголын том үр дүн, нөлөөллийн ажил боллоо. Мөн хариуцлагыг нэмэгдүүлэх 13 ажлын чиг үүргийг ЗГ-т хүргүүлээ.

Хууль эрх зүйн “Гурван төгөлдөршил” бодлого хэрэгжүүлэхээр ажлын хэсгүүд ажиллаж байна

2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан 126 гишүүнтэй шинэ парламентын өмнө хууль эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх өндөр хариуцлага бий. Тийм учраас шинэ парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа баримтлах үндсэн ГУРВАН чиглэлээ тодорхойлсон юм.

1 Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

2 Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэлд анхаарна.

3 Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргаж ажиллана.

Энэ хүрээнд УИХ-ын даргын захирамжаар 80 орчим ажлын хэсэг байгуулагдан, ажиллаж байна.



Н.БАТСҮМБЭРЭЛ
УИХ-ын гишүүн

1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь цаг үеэсээ хоцрогдсон төдийгүй хэт ерөнхий хэлбэрээр бичигдсэн учир хууль, эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай болж УИХ-аас ажлын хэсэг гаргасан юм. Гурван төгөлдөршил бодлогын хүрээнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө бүхий үнэт зүйлстэй улс орнуудад тайван жагсаал хийх нь зүй ёсны хэрэг бөгөөд бусад улс орны сайн туршлага, иргэний нийгмийн байгууллагуудын санал зэргийг харгалзан үзэж уг хуулийн төслөө бид боловсруулж байна.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Хууль хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй үзэл санаа бүхий байх, нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргадаг болох, хуулийг иж бүрэн зохицуулалттай, тодорхой, ойлгомжтой болгож, хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлоход “ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ”-ийн зорилго оршиж буй. Энэ парламент хууль хүний эрхийн зөрчилгүй байхад анхаарч ажиллахаар зорьж байгаа.



21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ УРАГШИЛЛАА

Улсын Их Хурал мега төслүүд хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал “Гашуунсухайт-Ганцмод” хил холболтын төмөр замын төсөл гацаанаас гарсан. Үр дүнд нь экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал хэмжээг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх юм.

2024.12.27

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан юм.

2025.02.14

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажууллаа.

2025.03.27

Гашуунсухайт-Ганцмод боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталлаа.

ЗАМЫН-ҮҮД, ЭРЭЭНИЙ
БООМТ ТӨМӨР ЗАМААР
ХОЛБОГДСОНООС ХОЙШ

70 орчим жилийн

ДАРАА ӨМНӨД ХӨРШТЭЙГӨӨ
ТӨМӨР ЗАМААР ХОЛБОГДОХ

ХОЁР ДАХЬ

БООМТЫН ҮҮД, ХААЛГА
НЭЭГДЛЭЭ.



Н.БАТСҮМБЭРЭЛ

УИХ-ын гишүүн

Хамтарсан Засгийн газар байгуулагдаад хэдхэн сар болж байгаа ч 3 улстай маш том гэрээнүүд байгуулж чадлаа. Үүний нэг нь 2024-2028 оны төлөвлөгөөнд тусгагдсан 14 мега төслийн нэгд эрэмбэлэгдэх “Гашуунсухайт-Ганцмод” төсөл дээр хамтран ажиллах “Чайна Энержи”-тэй байгуулсан гэрээ юм. Төслийн үр дүн гарна.

УРАНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ХУРИМТЛАЛЫН САН АРВИЖНА



Дэлхий нийтээрээ цөмийн эрчим хүчийг ногоон буюу тогтвортой цэвэр эх үүсвэр хэмээн зарлаж байна. Дэлхийн зах зээлд цөмийн түлш ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа.

Манай улсад 192,2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3%-ийг бүрдүүлж, нөөцийн хэмжээгээр дэлхийд 10-д жагсаж байгаа юм. Тэгвэл Монгол Улс үүнд анхаарлаа хандуулан урт хугацааны хөгжлийн бодлогодоо энэ талаар тусгаж, тодорхой ажил хийсээр байна. Тухайлбал, энэ хүрээнд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас өргөн барьж, УИХ-ын чуулганы /2025.01.09/-ний өдрийн хуралдаанаар баталлаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар

- Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах “Дулаан-Уул”, “Зөвч-Овоо”, “Өмнөт” гэсэн талбайд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн **34** хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр /АМНАТ/ болон **10** хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг тусгав;
- Засгийн газар **10%** -ийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг эзэмшсэнээр бусад энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжид ноогдол ашиг хүртэнэ;
- Хувьцаанд ноогдох хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байх бүтээгдэхүүний **10** хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авах боломж бүрдлээ.



Н.БАТСҮМБЭРЭЛ
УИХ-ын гишүүн

Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тууштай хэрэгжүүлэх, шинэчлэлийг тухай бүр цаг алдахгүй хийж, засаглалыг сайжруулаад явах нь чухал.

ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ЗАЛУУСЫН ТОО 65% БУУРНА

Зөвшөөрлийн тухай хууль
Батлагдсан огноо 2025.05.30

Цахим мөрийтэй тоглоомын хамгийн том хор уршиг нь “донтолт”. Үүнээс үүдэн залуус амьдралаараа бооцоо тавьж, нийгэмд хөл алдаж байна. Амьдралаа алдаж, өр зээлд орсон олон монгол хүн, олон өрх гэрийн зовлон бидний өмнө байгаа нь нууц биш! Иймд улсын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн ажлын хэсгийг ахлан ажиллаж, УИХ-аар хэлэлцэн баталлаа.

“Цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлж, бусдад их хэмжээний хохирол учруулбал 2-8 жилийн ХОРИХ ялтай



Эдийн засгийн гэмт хэргийн ХОХИРОГЧДЫН 50% нь 30-39 насныхан

- # 2023 онд эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд 417.2 тэрбум₮ хохирол учирсан!
- # Мөрийтэй тоглоомын 1XBET сайтаар манай улсаас 1.7 ихнаяд буюу 500 сая\$ 110 гаруй агентаар дамжин гадагш гарсан!
- # Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаа идэвхтэй явуулж ирсэн!



Хууль батлагдсанаар гарах ЭЭРЭГ ҮР ДҮН

- + Энэ чиглэлийн платформууд хориглогдож, зар сурталчилгаа, агентуудын үйл ажиллагаа бүр мөсөн зогсоно;
- + Цахим мөрийтэй тоглоом тоглох залуусын тоо 65% буурна;
- + Гадагш хяналтгүй гарч буй 500 сая ам.долларт зохих байгууллагаас хяналт тавих боломж бүрдэнэ;
- + Хүүхэд, залуучуудын мөрийт болон бооцоот тоглоом тоглож сэтгэл зүйн хувьд донтох, эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлнэ;
- + Мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэт хэвшсэн ойлголтыг өөрчилж, хүүхэд, залуучуудыг бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд уриалан дуудаж буй хууль бус сурталчилгаануудыг таслан зогсооно;

НИЙСЛЭЛИЙГ 14 ХОТОД ХУВААЖ, ХОТЫН ДАРГАА ИРГЭД ӨӨРСДӨӨ СОНГОНО

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
Батлагдсан огноо 2024.06.05

Хот, тосгодын эрх зүйн байдлын тухай хууль нь анхлан 1993 онд батлагдаж байсан. Түүнээс хойш нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нэлээд өөрчлөгдсөн. Мөн 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн дараа Монгол Улс засаг захиргааны шинэчлэлийг хийхдээ байсан хотуудаа татан буулгаад, засаг захиргааны нэгж буюу хотуудыг сум болгочихсон!

Улаанбаатар хотын хүн ам 1992 оноос хойш гурав дахин өссөн. Тухайн үедээ 575 мянган хүнтэй байсан бол өнөөдөр 1.7 сая хүн бүртгэлтэй байна. Ирж, буцдагтайгаа нийлэхээр 2 сая хүн амтай болж, суурьшлын бүс ч зургаа дахин тэлсэн. Үүнийгээ дагаад маш олон асуудал үүссэн нь нууц биш! Иймд хурсан асуудлыг шийдэхийн тулд дагуул болон бүс нутгийн хөгжлийг дэмжихээс өөр аргагүй.



Тухайлбал, УБ хот 9 дүүрэгтэй буюу дүүргийн 9 Засаг даргатай. Түүнчлэн иргэдийнхээ асуудлыг шийдэх нь байтугай хогоо ч толгой мэдээд ачих төсөв, эрх мэдэлгүй 204 хорооны Засаг даргатай. Үүн дээр нийслэлийн Засаг даргыг оруулан тооцвол 214 засаг даргатай. Гэхдээ эдгээр нь “улс төрийн нам”-ын оролцоотой буюу санал болгож томилогддог. Үүнийг өөрчилж иргэдээс шууд сонгогддог 14 Хотын захирагч, 42 хороололтой болох зорилгын дор уг хууль батлагдсан. Нэг ёсондоо нэгжүүдийг цөөлөхийн зэрэгцээ тодорхой эрх мэдэл олгож буйгаараа энэ хууль чамгүй ач холбогдолтой.

“Хүүхэд болон хөгжлийн бэрхшиэлтэй иргэний эрх хангагдаж байвал хүний эрх хангагдсан орчин гэж үзнэ. Цаашид УБ хот энэ төлөвлөлт рүү явна!

“20 МИНУТЫН ХОТ”
үзэл баримтлалаар 14 хотыг хөгжүүлж, дэд төв байгуулна





МОНГОЛ УЛСЫН
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ТҮҮХЭН ДЭХ
ЕС ДЭХ УЛСЫН ИХ ХУРАЛ

